

Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2025.10.27

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын Холбооны Нөөцийн Банк мөнгөний бодлогыг зөөлрүүлнэ гэсэн хүлээлт өсөж, АНУ-БНХАУ-ын худалдааны хэлэлцээр ахицтай байгаа нь хөрөнгө оруулагчдын өөдрөг хандлагыг дэмжсэнээр АНУ-ын хувьцааны фьючерс үнэ өсөв.
- АНУ болон Хятадын албаныхан Куала Лумпурт болсон АСЕАН-ы дээд хэмжээний уулзалтын үеэр худалдааны чухал асуудлаар “суурь ойлголцолд” хүрсэн явдал байв.
- Энэ долоо хоногт “7 гайхамшигт”-ын тав нь санхүүгийн тайлангаа зарлах гэж байна.
- Аж үйлдвэрлэл есдүгээр сард жилийн 6.5%-ийн өсөлттэй гарч таамгаас давсан бөгөөд экспортын хүчтэй өсөлт голлон дэмжлээ. Эдгээр үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад Хятадын эдийн засгийг сааруулж буй дотоод эрэлтийн сул байдал үргэлжилж байна.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.10.20-10.26

АНУ-ЫН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД ДЭЭД ҮНЭ ДАХИН ШИНЭЧИЛЛЭЭ.

АНУ-ын хувьцааны фьючерсүүд өнөөдөр өглөө өсөлттэй нээгдлээ. АНУ-ын Холбооны Нөөцийн Банк мөнгөний бодлогыг зөөлрүүлнэ гэсэн хүлээлт өсөж, АНУ-БНХАУ-ын худалдааны хэлэлцээр ахицтай байгаа нь хөрөнгө оруулагчдын өөдрөг хандлагыг дэмжсэнээр АНУ-ын хувьцааны фьючерс үнэ өсөв. S&P 500 фьючерс 0.7%-иар нэмэгдэж 6,873.75 нэгжид, Nasdaq 100 фьючерс 0.9%-иар өсөж 25,726.75 нэгжид, Dow Jones фьючерс 0.6%-иар өсөн 47,676.0 нэгжид арилжаалагдав.

ХНС-ын хурал ойртож, АНУ-БНХАУ хэлэлцээ урагшилж байна. Баасан гарагт Dow Jones 1%, S&P 500 0.8%, Nasdaq Composite 1.2%-иар өссөн. Өнгөрсөн долоо хоногт нийтлэгдсэн инфляцын үзүүлэлт хүлээлтээс сул гарч, Холбооны Нөөц ирэх аравдугаар сарын 29-нд хүлээлтийн дагуу бодлогын хүүг 25 суурь нэгжээр бууруулна гэсэн таамаглалыг бататгав. Дэлхийн даяарх шинжээчид бүгд дуу нэгтэйгээр ирэх долоо хоногт хүү 25 суурь нэгжээр буурахыг хүлээж байна. Мөн 12-р сард дахин 25 суурь нэгжээр, 2026 оны эхэнд 50 суурь нэгжээр буурах хүлээлтийг үүсгээд байна.

Харин өөдрөг хандлагыг улам нэмэгдүүлсэн өөр нэг үйл явдал нь АНУ болон Хятадын албаныхан Куала Лумпурт болсон АСЕАН-ы дээд хэмжээний уулзалтын үеэр худалдааны чухал асуудлаар “суурь ойлголцолд” хүрсэн явдал байв. АНУ-ын Сангийн сайд Скотт Бессент хэлэхдээ талууд нэмэлт тарифын сүрдүүлэг болон Хятадын ховор металл экспортод тавихаар төлөвлөсөн хязгаарлалтаа түр түдгэлзүүлэхээр тохиролцсон гэлээ. Энэ нь АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп, Хятадын дарга Ши Жиньпин нар энэ долоо хоногт уулзаж хэлэлцээрийг албан ёсоор тохирох зам гарч байгааг харуулж байна. Трамп “Бид Хятадтай тохиролцоно гэж бодож байна” хэмээн мэдэгдсэн.

Том технологийн компанийн тайлан анхаарлын төвд байна. Энэ долоо хоногт “7 гайхамшигт”-ын тав нь санхүүгийн тайлангаа зарлах гэж байна. Microsoft (NASDAQ:MSFT), Meta Platforms (NASDAQ:META), Alphabet (NASDAQ:GOOGL) лхагва гарагт, харин Apple (NASDAQ:AAPL), Amazon (NASDAQ:AMZN) пүрэв гарагт тайлангаа мэдээлнэ. Хөрөнгө оруулагчид хиймэл оюун ухааны хөрөнгө оруулалт, үүлэн үйлчилгээний эрэлт, хэрэглэгчийн зарцуулалтын чиг хандлагад онцгой анхаарал хандуулах төлөвтэй.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.10.20 – 10.26

БНХАУ-ЫН ТЕХНОЛОГИЙН САЛБАР ӨСЧ БАЙНА.

БНХАУ-ын эдийн засгийн дотоод эрэлт сул байгааг харуулсан макро үзүүлэлтүүд гарсан ч технологид төвлөрсөн хөрөнгө оруулагчдын ачаар эх газрын Хятадын хөрөнгийн зах зээл өсөлттэй байв. CSI 300 индекс 3.24%, Шанхайн нийлмэл индекс 2.88%-иар нэмэгдсэн гэж FactSet мэдээлэв. Харин Хонг Конгийн Hang Seng индекс 3.62%-иар өсөв.

Хятад улсын Статистикийн товчоо даваа гарагт мэдээлэхдээ тус улсын эдийн засаг гуравдугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.8%-иар өссөн нь энэ оны 5%-ийн орчим өсөлтийн зорилтыг хангах “бат бөх суурь” болж өгч байна гэв. Гэвч бусад үзүүлэлтүүд эдийн засаг сайнгүй байгааг илтгэлээ. Есдүгээр сард жижиглэн худалдааны борлуулалт жилийн 3.0%-ийн өсөлттэй гарсан нь өнгөрсөн арваннэгдүгээр сараас хойших хамгийн сул гүйцэтгэл болов. Мөн жилийн эхний есөн сарын хугацаанд үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт 0.5%-иар буурсан нь шинжээчдийн хүлээлтэд нийцсэнгүй. Харин аж үйлдвэрлэл есдүгээр сард жилийн 6.5%-ийн өсөлттэй гарч таамгаас давсан бөгөөд экспортын хүчтэй өсөлт голлон дэмжлээ. Эдгээр үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад Хятадын эдийн засгийг сааруулж буй дотоод эрэлтийн сул байдал үргэлжилж байна.

Хүмүүсийг хадгалахаас илүүтэйгээр зарцуулалт руу чиглүүлэх нь гол даалгавар болжээ. Дэлхий даяар худалдааны хамгаалалтад чиглэсэн бодлогууд нэмэгдэж буй энэ үед улам бүр чухал болсон байна. Гэвч олон жил үргэлжилсэн орон сууцны салбарын хямрал болон дефляцийн дарамт хэрэглэгчдийн зарцуулалтыг сулруулсаар байна. Бодлогын тал дээр БНХАУ нь ирэх таван жилд шинжлэх ухаан, технологийн салбарт “өөртөө түшиглэх боломж, чадавхыг эрс нэмэгдүүлэх”-ээр зорьж буйгаа мэдэгдэв. Мөн үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хэмжээг “зохистой” түвшинд хадгалж, орчин үеийн аж үйлдвэрийн бүтцийг бүрдүүлэхээ амлалаа гэж Bloomberg агентлаг төрийн хэвлэлээс эш татав. Эдгээр мэдэгдэл өнгөрсөн пүрэв гарагт өндөрлөсөн намын IV хуралдааны дараа нийтлэгдсэн бөгөөд уг хурал нь 2026-2030 онд хэрэгжүүлэх БНХАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтыг тодорхойлох 15-р таван жилийн төлөвлөгөөний гол сэдвүүдийг батлахад чиглэсэн юм.



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
CLF CLIFFS	AGNC AGNC	KO Coca-Cola	NFLX NETFLIX	APH Amphenol	TSLA TESLA	AAL American Airlines	INTC intel	PG P&G
DX DYNEX CAPITAL INC.	CCK CROWN	GE GE Aerospace	ISRG INTUITIVE SURGICAL*	GEV GE VERNOVA	IBM IBM	FCX First Quantum Minerals	NEM Newmont	BAH Booz Allen Hamilton
STRR Star Equity Holdings	ZION ZIONS BANCORPORATION	LMT LOCKHEED MARTIN	TXN TEXAS INSTRUMENTS	VRTV VERTIV	KMI KINDER MORGAN	HON Honeywell	ALK Alaska AIRLINES	ENTX GENTEX CORPORATION
SDVY SANDVIK	STLD Steel Dynamics, Inc.	ELV Elevance Health	COF Capital One	BSX Boston Scientific	QSP QuantumSpace	DOV Dow	NXT nexttracker	FLG flagstar
SMIT Summit Therapeutics	CADE CADENCE BANK	RTX RTX	EQT EQT	HIL Hilton	CCS CENTURY COMMUNITIES	DOV DOVER	DECK DECKERS BRANDS	GD GENERAL DYNAMICS
HBT HBT Financial	BOKF BOK FINANCIAL	PM PHILIP MORRIS INTERNATIONAL	MAT MATTEL	T AT&T	SAP SAP	HAS Hasbro	BYD BOYD	ITW ITW
	FLXS FLEXSTEEL	NOC NORTHROP GRUMMAN	OMC Omicron Group	TECK Teck	TCB TEXAS CAPITAL BANK	NOK NOKIA	F Ford	FHB First Hawaiian Bank
	WINTR WINTRUST	MMM 3M	WCN Waste Connections, Inc.	TMO taylor morrison	LRCX Lam RESEARCH	NOKIA NOKIA	COMST COMFORT SYSTEMS USA	EAP GRAFTECH International
	WASH NATIONAL TRUST BANK FINANCIAL INC.	GM gm	NBHC National Bank Holdings	THF ThermoFisher SCIENTIFIC	AA Alcoa	T T-Mobile	LUV Associated Bank	HCA HCA Healthcare
	WRB Berkley	EFX EQUIFAX	EWBC EAST WEST BANK	NVR NVR	KNT KNIGHT SWIFT	SWFT AutoNation	DOO PROKIAN REALTY TRUST	STEL stellor BANCORP, INC.

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
KDP Keurig Dr Pepper	CLS Celestica	SOFI SoFi	ENPH ENPHASE	VZ verizon	META Meta	LLY Lilly	AMZN amazon	XOM ExxonMobil
CRI carter's	NXPI NXP	UNH UNITEDHEALTH GROUP	BE Bloomenergy	BA BOEING	MSFT Microsoft	MRK MERCK	AAPL Apple	CVX Chevron
SIFY sify	CAR avis budget group	PYPL PayPal	SFT SEAGATE	CVS CVS Health	GOOGL Alphabet	CMCSA COMCAST	COIN coinbase	ABBV abbvie
DEA Easterly Government Properties	RMBS Rambus	UPS ups	ONEK ONEOK	CAT CATERPILLAR	CMG CHIPOTLE MEXICAN GRILL	RBLX ROBLOX	RDDT reddit	CNI CNI
BMRC Bank of Marin	WM WASTE MANAGEMENT	GLW CORNING	V VISA	FI fiserv.	CVNA CARVANA NOW	OWL BLUE OWL	WDC Western Digital	LYB lyondellbasell
RVTY revvity	CDNS cadence	HSBC HSBC	BKNG BOOKING HOLDINGS	CNC CENTENE Corporation	SNOW servicenow	INSM insmed	MSTR Strategy	LIN Linde
BOH Bank of Hawaii	WHR Whirlpool	RCL Royal Caribbean Group	EA Electronic Arts	ETSY Etsy	SBIU Starbucks	PWR QUANTA SERVICES, INC.	RBOT IOT	CHTR Charter COMMUNICATIONS
DQ DAOO NEW ENERGY	CR CRANE	JBLU jetBlue	MGD newgold	ADP ADP	NEI mercado libre	COMM COMMSCOPE	ROK ROCKET Companies, Inc.	CL COLGATE-PALMOLIVE
BCBP BCB Bank	NUE NUCOR	BHI DR-HORTON	CAKE The Cheesecake Factory	FLEX flex	SFM SPROUTS FARMERS MARKET	EPD Enterprise Products Partners LP	NET CLOUDFLARE	CBSE Cboe
ARLP ALLIANCE TECHNOLOGY PARTNERS LP	AMKR Amkor Technology	W wayfair	MDLZ Mondelez International	KHC Kraft Heinz	AEM AGNICO EAGLE	AAP Advanced Auto Parts	ROKU ROKU	CVE cenovus

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers